

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ  
/2021.01.03-2021.03.24/**

2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар нийт 49 албан бичиг ирсэн ба үүнээс хариутай бичиг 18, хариугүй бичиг 31 байгаагаас Удирдлагад 2, Захиргааны албанд 33, Үйлдвэрлэл, технологийн албанд 14 албан бичиг хуваарилагдан тус тус хугацаандаа, бүрэн шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай, хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.37 хоногтой байна.


Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж жигдэрсэн.

Манай байгууллагаас 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 37 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулан графикаар харуулав.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧИГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2022 оны 01 дүгээр улирлыг, 2021 оны 01 дүгээр улирлынхтай харьцуулахад/



**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2022 оны 01-р улирлыг, 2021 оны 01-р улирлынхтай харьцуулахад, тоон үзүүлэлтээр/

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2022 оны 1-р улирал	49	18	31	2.37	37
2021 оны 1-р улирал	53	23	30	2.18	39

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 2.18 байсан бол энэ онд 2.37 хоног байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил дутагдал, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Г. Энхбаяр* ЭНХЗАЯА

ТАЙЛАН ГАРГАСАН:

БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД

ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *М. Мөнхдулам* М.МӨНХДУЛАМ